

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 сар 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн 11.30 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Д.Нямбаяр 89242 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Л.Цэгмид 51830 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Л.Мягмаржав 3870 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Эй Ди Эм Эм Ди 94657 ширхэг хувьцааны саналаар /гүйцэтгэх захирагч/

Н. Түвшинзаяа 10 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр/

Б.Отгонбаатар 10 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр/

А. Балжинням 10 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр/

240005 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 81.1 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Б.Төрсайхан, ердийн гишүүн Д.Бямбажал нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Л.Мягмаржав удирдав.

Хурлаар:

1. Компанийн 2019 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмшө дуусгавар болгох ;
4. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох;
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох;

Л.Мягмаржав: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын гишүүн Ц.Оргил хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 81.1% хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрөлийг хурлын даргад өгөв.

Хурал 12.00 минутанд эхлэв.

СОНССОН НЬ :

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** За та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хурлаа эхэлье энэ удаагийн хурлаар дараах дэгийн дагуу асуудалыг хэлэлцэнээ. Ингээд хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулья.

1. Компанийн 2019 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
2. Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох ;
4. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох;
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цапин, урамшуулалын хэмжээг тогтоох асуудлыг тус тус хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын дагуу Гүйцэтгэх захирал Д. Нямбаяр: 2019 оны үйл ажиллагааны тайланг уншиж танилцуулав.

Санхүүгийн үйл ажиллагааны тайланг компанийн Ерөнхий нягтлан бодогч Н.Одмаа уншиж танилцуулав.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Шинээр хувьцаа эзэмшигч орж ирсэнтэй холбогдуулан компанийн талаар товч танилцуулга хийв. 2019 онд ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Компанийн үйл ажиллагааны талаар өмнөх хувьцаа эзэмшигч Б.Анхбаяр нэлээн шүүмжлэлтэй хандаж байсан. Гэхдээ компанийн үндсэн хөрөнгө зарагдаж үрэгдсэн юм байхгүй. Өр төлбөр бас байхгүй байгаа нь компани өсөн дэвжих бүрэн боломжтой гэж миний бие үзэж байна.

2020 оны хувьд онц байдал зарласантай холбоотой үйл ажиллагаа бага зэрэг муудсан.

-**Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр:** Санхүүгийн ямар програам дээр ажиллаж байгаа вэ?

-Ерөнхий нягтлан Н. Одмаа: Санхүүгийн импакт программ дээр ажилладаг.

-Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Элэгдэл хорогдолоо яаж тооцдог юм бэ? Элэгдэлийн зардалаа тогтмол тооцдог уу

-Ерөнхий нягтлан Н. Одмаа: Элэгдэл тооцох шулуун шугамын аргаар элэгдлийн зардлаа тогтмол тооцдог.

-Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр : Хөрөнгөө капиталжуулж байна уу ?

-Ерөнхий нягтлан Н. Одмаа: Хөрөнгөө капиталжуулж байгаа. 2019 онд 56,823,971 төгрөгийн засварын ажил хийгдсэн ба үүний 44,629,736 төгрөгөөр үндсэн хөрөнгөө нэмэгдүүлж капиталжуулсан байгаа.

-Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Миний хувьд ноогдол ашиг нэг их чухал бишээ хөрөнгө нэмэгдэж хувьцаа үнэ цэнэ цэнэ өсөх нь чухал

- Хурлын дарга Л.Мягмаржав: Компанийн хөрөнгөн дээр 2 давхар байшин нэмэгдэж орж ирэх ёстой Баланс дээрээ тусгасан уу?

-Гүйцэтгэх захирал Д. Нямбаяр: Тусгаагүй байгаа

- Хурлын дарга Л.Мягмаржав: Ойрын хугацаанд үнэлгээг нь тогтоож тусгаад ТУЗ-д тайлагнаарай.

- За дараагийн асуудалдаа орьё. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох талаар байгаа миний бодлоор ТУЗ-ийн 3 гишүүнээсээ ТУЗ-аас гарах өргөдөлийг нь аваад нөхөн сонгууль явуулаад ТУЗ дээрээ асуудал шийдэх боломж байсан гэж харж байна.

-Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: ТУЗ –аа нэг жилийн хугацаатай сонгоод явах боломж байхгүй юмуу

-Гүйцэтгэх захирал Д. Нямбаяр: Компанийн дүрмэнд 3 жилийн хугацаатай томилно гэсэн заалттай байгаа дүрэм бол компанийн хууль гэсэн үгээ хэрэв 1 жил болговол компанийн дүрэмээ шинэчлэх шаардлагатай болно энэ удаа манай хурлаар хэлэлцэх асуудалд ороогүй.

-Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр: Миний зүгээс шинээр ТУЗ-д өөрийн төлөөлөл болох ердийн гишүүн Н.Түвшинзаяа, Отгонбаатар, хараат бус гишүүн А.Балжинням нарыг хуучин зургаан гишүүнийг дэвшүүлж байна. Үүнд: ердийн гишүүн болох Д.Нямбаяр, Л.Цэгмид, Л.Мягмаржав, Д.Бямбажал, хараат бус гишүүн С.Мөнхгэрэл, Б.Төрсайхан нарыг дэвшүүлээд батлах саналтай байна

- Хурлын дарга Л.Мягмаржав: Саналаа саналын хуудасаар өгнө.

Хурал 15 минут завсарлаад шинээр сонгогдсон ТУЗ-ийн санал хураасан дүнг танилцуулж батлагдсан тогтоолыг хурлын дарга уншиж танилцуулав.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** -За дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох асуудал өмнө ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын цалин урамшуулал – 450000 төгрөг
ТУЗ-ийн гишүүдийн цалин – 320000 төгрөг байсан .Хэрэв хөдөлмөр хөлсний доод хэмжээ өөрчлөгдвөл ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин урамшуулал дагаж өөрчлөгдөх журамтай.

-**Хувьцаа эзэмшигч Н.Өлзийбаяр:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулалыг дараах хувь хэмжээгээр тогтоомоор .

Үүнд: ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн нэг сарын цалинг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, ердийн болон хараат бус гишүүдийн урамшуулалыг доорхи хувь хэмжээгээр тооцож жилийн эцэст нэг удаа тус тус бодож олгох

Үүнд:

- ТУЗ-ийн даргын урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хараат бус гишүүдийн урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 1 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн ердийн гишүүдийн урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 0.5 дахин нэмэгдүүлсэнээр

Тооцож олгох саналтай байна.

- **Хурлын дарга Л.Мягмаржав:** Оөр санал байна уу? Байхгүй бол саналаа хураагаад хуралаа өндөрлөө .

Хувьцаа эзэмшигч: Л.Цэгмид Хурал хуралдуулахтай холбоотой удирдлагын зардлыг тухай бүрд тооцож олгох нь зүйтэй. Тогтоолын төсөлд удирдлагын зардлын талаар тусгамаар байна.

Хэлэлцэх асуудал дуусав.

Асуух зүйл байна уу.

Байхгүй бол саналаа өгөөд хурлаа завсарлах уу.

Тооллогын комисс саналаа хурааж тоолж дүнгээ гаргаж уншиж танилцуулав.

ТУЗ-ийн хурлыг үргэлжүүлэн хийхээр тогтов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

2.Компани 2019 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсаныг дурьдсугай.

3.Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

4.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.

5. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

- Л.Мягмаржав
- Д.Нямбаяр
- Д.Бямбажал
- Л.Цэгмид
- Н.Түвшинзаяа
- Б.Отгонбаатар

2. 3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- А.Балжинням
- С.Мөнхгэрэл
- Б.Төрсайхан

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

8.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулалыг доорхи хувь хэмжээгээр баталсугай.

Үүнд:

9. ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн нэг сарын цалинг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгосугай.

10. ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, ердийн болон хараат бус гишүүдийн урамшуулалыг доорхи хувь хэмжээгээр тооцож жилийн эцэст нэг удаа тус тус бодож олгохыг ерөнхий нягтланд үүрэг болгосугай.

Үүнд:

- ТУЗ-ийн даргын урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хараат бус гишүүдийн урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 1 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн ердийн гишүүдийн урамшуулалыг 1 жилийн цалингийн хэмжээг 0.5 дахин нэмэгдүүлсэнээр

11. Хурал хуралдуулахтай холбоотой удирдлагын зардлыг тухай бүрд тооцож олгохыг Гүйцэтгэх захирал Д.Нямбаярт зөвшөөрсүгэй.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 13 цаг 30 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

/Л.МЯГМАРЖАВ/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :

/А.АРИУНСАЙН/